

Journalist Byambasuren gives interview to Irina Morozova and Enkhbaatar Munkhsaruul (with some translation into Russian) in Khovd in August 2012.

- Тэгэхээр нэг зэвсэг гэдэг утгаараа бас нэг чухал хэрэглэгдэхүүн болж байсан гэдэг утгаараа, сонин тэр дундаа сэтгүүлчид нар бол чухал. Монголд өөрчлөн байгуулалт явагдаад, тухайн өөрчлөн байгуулалт явагдаж, тэр ил тод байдал, тэр тодорхой хэмжээгээр дотоодыг илчлэх ч гэдэг юмуу тиймэрхүү байдлын үед сэтгүүлчид ямар үүрэг рольтой оролцож, Ховдын хэмжээнд ямар одоо шинэ шинэ утга агуулга бүхий нийтлэлүүд хэвлэж, ямар нийтлэл ярилцлагууд авч нийтлэж байсан юм бол. Бүр одоо улс төрийн үйл явц одоо хурц оргил үедээ Ховдод оюутны жагсаал цуглаан болсон, Улаанбаатарт болсон тэр улс төрийн өлсгөлөн, жагсаал цуглаанууд, улс төрийн товчоо огцрох тэр үеийн мөчийн бас тодорхой хэмжээгээр тухайн үйл явцыг бас Ховдын ард түмэнд таниулан ойлгуулах журмаар бас сонингийн хэвлэн нийтэлсэн материал зэргээс хамаарна ш дээ. Жишээ нь, тухайн үед гарч байсан нийтлэл мэдээлэл, тухайн үед барьж байсан сэтгүүлчдийн нийтлэлийн бодлого, тиймэрхүү нөхцөл байдал. Тэгээд цааш нь ардчилсан сонин, ардчилсан хувьсгал ялаад, шинэ засаг төр тогтоод, эдийн засаг улс төрийн хувьд шинэчлэл явагдахад, сонин хэвлэл газруудын хувьд дотоод эдийн засгийн асуудлаас эхлүүлээд ажилчдын нийгмийн асуудал, тэдгээр нь хэрхэн яаж өөрчлөгдсөн, тэр нь таны амьдрал дээр хэрхэн яаж туссан юм гэдэг дээр, иймэрхүү юмнууд дээр хэлмээр санагдаж байна. **/Энхбаатар/**
- Ерөөсөө би 1985 онд Их сургуулийн сэтгүүлчийн анги төгсөж ирээд Ховд аймгийн Хөдөлмөр сонины хэвлэх үйлдвэрийн газарт ажилд орсон. Тэгэхэд социализмын бүтээн байгуулалтын үе байсан. Тэгээд хөдөлмөр сонинг гараар тугалган үсгээ өрдөг. Тэгээд хэвлэх машинтай СЗ гэдэг. Тэндээ сонингоо хэвлэдэг. Сонин маань болохоор 12000 хувиар хэвлэгдээд, ерөөсөө Ховд аймгийн 90000 хүн амын одоо байгууллага, тэр үеийн төсвийн байгууллагуудад бүх хүмүүст сонин жигд хүрдэг, айл бүрийн гэрт тэр сонин хүрдэг байсан байхгүй юу. Тэгээд болбол бид нар цалингаа тогтмол авдаг байсан. Сурвалжлагч нар 600 төгрөгний цалинтай, эрхлэгч нар бол 700 төгрөгний цалинтай байсан. Сонин хэвлэж байгаа үсэг өрөгч, хэвлэгч,

сонины редакци нь, сэтгүүлчдийн баг нь тусдаа, эдийн засгийн баг нь бас тусдаа байсан, тэгээд редакторууд нь тусдаа. Тэр үед хамгийн хэцүү нь юм юу байсан юм бэ гэхлээр, тэр үед галавлет гэж байсан. Бүх хэвлэгдэж гарч байгаа бүх үг үсэг, сонины хэл найруулгыг хянадаг галавлет ажилладаг байсан.

- Переведите, пожалуйста, что она говорит?
- **Interpreter:** Она работала журналистом после окончания Университета в Улаанбааторе. Она приехала Ховд и работала в редакции газеты “Труд”. Это газета печаталась 12000 экземпляров. И каждая семья получала эту газету. В то время в редакций газеты работали работники которые печатали газету и ещё редакция отдельно работала.
- То есть, это был “Хөдөлмөр”, именно который издавался в Ховде. Именно ховдинский. Он не улан-баторский, не национальный, а именно ховдинский, да?
- **Interpreter:** в то время директор редакции получил 700 тугриков, а журналист получил 600 тугриков.
- ***А, вот очень интересно. Можно спросить немного о её жизни там, где она родилась, когда?***
- 1963 онд Ховд аймагт төрсөн. Ховд аймгийн Ховд суманд Улаанхуаран гэдэг газар, хөдөө төрсөн, малчны гэрт. Тэгээд 1971 онд энд Ховдод 10 жилийн дунд сургуульд ороод 1981 онд 10-р ангиа төгсөөд, МУИС-д ороод 4 жил сураад, сэтгүүлч мэргэжлээр төгсөөд, Ховдод Хөдөлмөр сонинд ирж ажилласан. Энэ Хөдөлмөр сонин бол одоо 70-аад жилийн түүхтэй. 1945 онд эх орны дайны үед анх гарсан. Их түүхтэй сонин байгаа. Тэр үед сонингаа гаргаж байсан түүхэнд бол лааны гэрэлд үсгээ өрдөг байсан гэсэн.
- **Interpreter:** Она родилась 1963 году на территории сомона Ховда в семье скотовода. 1971 году она поступила в среднюю школу и окончила 1981 году. Потом она поехала учиться в МУИС. И истории газета “Труд”, он издавался. впервые 1945 году. В начале работники издавали газеты при свечи.

- ***А вот.. она может рассказать о своей жизни в Улаанбааторе? Вот она приехала из Ховда из западной Монголии в Улаанбаатар. Как ей там понравились, как она там жила, когда училась?***
- Тэгэхээр Та одоо оюутан болоод Улаанбаатарт очжээ. Тэгээд тухайн үед Улаанбаатарт очоод ямар сэтгэгдэл төрж байсан бэ? Ямар амьдралтай байсан бэ?
- Би Их сургууль очоод оюутны байранд амьдарсан. Ховдоос Улаанбаатар луу онгоц явдаг байсан, тэр үед. Тэгээд хичээлдээ очоод бүртгүүлээд, айлд байж байгаад, тэгээд оюутны байранд амьдарсан. Тэгээд оюутны байранд 4 жил амьдарсан бөгөөд тэгээд сэтгүүлчийн мэргэжил эзэмшиж төгссөн. Улаанбаатарт очиход ямар нэгэн бэрхшээл тохиолдоогүй. Тэр бид нар оюутны цалин авдаг байсан. Оюутан хүн сайн сурах юм бол нэмэгдэлтэй, хичээлээ сайн хийх юм бол цалингаа аваад л төгсдөг, яг тэр социализмын үеийн нэг хэвээр явж ирсэн.
- **Interpreter:** когда она стала студентом, она получала стипендию. В то время из Ховда летел самолёт в Улаанбаатар. Она приехала в Улаанбаатар самолётом. Сначала она жила в одной из её родственников, но потом она жила в общежитие при МУИС. Жизнь было нормально, даже хорошо.
- ***А вот.. какая была студентческая среда? Был ли какие-нибудь студентские союзы? Как они проводили свободное время? Что они там обсуждали между собой? Что их интересовало тогда? Погода какая была?***
- Эгч ээ, танай сургуулийн оюутнуудын дунд Оюутны холбоо гэж байсан уу?
- Тэр үед МХЗЭ-ийн үүр гэж байсан, бид бүгдээрээ эвлэлийн үүрийн гишүүн байсан. Оюутны холбоо манай Их сургуулийн хувьд бол байсан. Тэр үед бид нар Сангийн аж ахуйд ажиллаж ногоо хураадаг байсан. Намар болгон. Тэгээд ургацийн талбай дээр ажилчихаад, ногоо хурааж ирчихээд хичээлдээ ордог байсан. Сангийн аж хуй гэж байсан, тэр үед. Октябрын сангийн аж ахуй, нэг нь юу билээ дээ..., хоёр сангийн аж ахуй дээр ажиллаж байсан.
- ***Тэгээд оюутнууд одоо хоорондоо юуны тухай ярилцаж байдаг байсан бэ?***
- Бид нар ерөөсөө нөгөө нэг аймаг аймгаас оюутнууд ирдэг байсан. Оюутнууд хоорондоо юу ярьдаг байсан юм бэ гэхлээр ерөөсөө тэр үеийн бид нар чөлөөт

цагаа, тэр дотуур байрандаа хичээлээ хийнэ. Номын санд сууна. Тэгээд мэргэжлээрээ бид нар сонирхож байгаа хэвлэл номыг их судалдаг байсан. Бас их дуурь үзнэ. Шинэ гарсан кино үзнэ. Оросын хэвлэлүүдийг бас их захиалж уншина. Бид нарын орчин тийм л байсан. Өөр бид нарт хийгээд бар ч юм уу тийм одоогийнх шиг тийм байхгүй л байсан. Социализмын сэтгэлгээгээр явж байсан.

- **Interpreter:** В то время студенты работали в огородах в государственном хозяйстве осенью. В общежитие они занимались уроком, делали домашние задание, и во время свободного времени они смотрели опера и новые фильми, читали интересные книги согласно их прописи. Таким образом они провели свои свободное время. И вместе с ней учились студенты из разных аймаков Монголии. Они разговаривали между собой про их жизни, их городах. В то время не было так много место где можно проивести свои свободное время. Поэтому они большинство случай проводили свободное время в общежитий, в библиотеке, в кино театрах и читали книги.
- ***Какая вот у них там мода была ? Что и к чему они стремились ? Были ли у них какие-то кумиры студентческие? Кумиры, может быть, или это была музыка, я не знаю... там среди деятелей Монголии или, может, какие-то международные деятели?***
- **Interpreter:** Ещё она сказала, что в то время был Комитет монгольского революционного союз молодёжи. Каждый студент был членом этого союза.
- ***А вот ещё можно у неё спросить, что это означало, как становились членами этого союза, что они делали?***
- Тэгээд тухайн үед МХЗЭ-ийн үүр байх үед ...тэрний гишүүн үү?
- Бид бүгд гишүүн байсан. Эвлэлийн үүрээс ямар ажил зохион байгуулна, тэнд идэвхтэй оролцоно. Тэгээд л октярбрын баяр, Майн баяр болно тэрүүнд нэгдсэн журмаар жагсаад л, ура хашгираад л явна. Тийм л байсан даа.
- Хөдөлмөр сонин ер нь өдөр тутмын сонин юм уу, тогтмол гардаг уу?
- Хөдөлмөр сонин бол ерөөсөө өдөр тутмын сонин байсан, тэр социализмын үед 7 хоногт 4 удаа гардаг байсан.

- **Interpreter:** это газета была ежедневно выходила. 4 раза выходила в 7 дней. Студенты все были членами этого союза, они активно участвовали в каждом мероприятиях организованным этим союзам. И во время 1-ого Мая и день 7-ого Октября они участвовали в демонстрации, и кричали ура. Таким образом демонстрировали.
- Эгч ээ, нөгөө тухайн үед оюутнуудын дунд урлагийн шүтэн биширдэг дуучид байсан уу? Тухайн үед ямар урлаг шүтдэг байсан бэ?
- Тэр үед оюутны хавар гэж урлагийн наадам жил болгон болдог байсан. Тэр үеийн шүтэн биширдэг дуучин бол одоогийн энэ Инээмсэглэл хамтлаг, тэгээд Нармандах гээд дуучин байдаг ш дээ... УБИС-ийг төгссөн тэр үеийн дуучид одоогийнхоор бол од болж байсан. Мөн тэр үеийн гарч ирж байсан хамтлагуудыг бид дагаж дууриадаг байсан. Тэгэхэд бас Оюутнуудын дунд оюутны урлагийн хаврын яргуй наадмаас авъяаслаг хүмүүс тодорч гардаг. Оюутны хаврын наадам, намар ирээд оюутнуудын урлагийн үзлэг, анги болгон урлагийн үзлэг явуулдаг.
- **Interpreter:** В то время каждой весне организовали конкурс среди студентов. Конкурс назывался "Весна искусства". Из этого конкурса победители стали почти звездами. Так обнаруживается талант студента. И в то время была певица Нармандах, она была почти кумиром студентов, а также группа Улыбка которая была очень популярная в Монголии.
- ***Они что-нибудь слушали из зарубежной эстрады? Например, я не знаю там... АББА, Битлз... если слушали, - то на пластиках или у них были записи на кассетах?***
- Эгч ээ, гадаадынхнаас урлаг спортын ямар хүмүүсийг сонсдог байсан бэ, жишээлбэл Битлз ч юм уу, оросынхоос манайхан сонсдог байсан уу?
- Бид Италийн дуунуудыг их сонсдог байсан. Урд нь хагас сайн өдөр хагас ажилладаг байсан, бүтэн сайн өдөр бүтэн амардаг байсан. Бид оюутны байрандаа хагас сайн өдөр үдэшлэг зохион байгуулдаг байсан. Италийн Сан-Ремо-гийн дуунуудыг сонирхдог. Тэр үед Битлзийн дуунууд яг орж ирж байсан... Мөн Алла Пугачевагийн

дуунуудыг шүтдэг байсан, яг тэр үед сая сая сарнайг сонсдог байсан, оюутан болгон мэддэг, дуулдаг байсан.

- **Interpreter:** итальянские песни были очень популярно среди студентов. И ещё только начал слушать Битлз, песни Алла Пугачёвы тоже слушали, каждый студент знал особенно её песню “Миллионы, миллионы алых роз”. И тогда 6 день работали, только отдыхали в воскресенье. Вечером в субботу организовали вечеринку сред студентов. Они пели, танцевали песнями знаменитых певцов.
- ***А они слушали эти песни на пластинке или на магнитофоне?***
- Тэгээд та хэд дугаа сонсдог байхдаа пянзаар сонсдог байсан уу, магнитофон дээр сонсдог байсан уу?
- Пянг, пянг ашигладаг байсан. Бичлэг тавьдаг. Тэгээд бас магнитофон дээр хурааж авдаг байсан. Ихэвчлэн пянгаас сонсдог байсан.
- **Interpreter:** в большинстве случаев они слушали на пластинках. Редком случае на магнитофоне слушали.
- ***Интересно, когда она потом вернулась в Ховд, как она себе чувствовала, как она нашла Ховд, изменилось ли что-то после её возвращения из Улаанбаатара?***
- Тэгээд таныг төгсөөд Ховддоо ирэхэд Ховд өөрчлөгдсөн байсан уу? Ямархуу сэтгэгдэл танд төрж байсан бэ, төгсөөд ирэхэд?
- Төгсөөд ирэхэд Ховд өөрчлөгдсөн байсан. Тэгээд бас л яг Ховдод ирээд л бид нар бас Хэвлэх үйлдвэр гэдэг том албан газар ирсэн ш дээ. Тэр үед албан газар гэж ярьдаг байсан. Тэнд бас Эвлэлийн үүр гэж байсан, Хувьсгалт нам гэж байсан. Нэг нам дангаараа байсан, МАХН гэж байсан ш дээ. Миний хамт ажиллаж байсан хүмүүс ихэнх нь хувьсгалт намын гишүүн байсан. Тэд нар төлөвлөгөөтэй, төлөвлөгөөг биелүүлдэг, социалист уралдаанд үүрэг авдаг, тэр үүргээ биелүүлдэг. Тэр үед ямар олон нийтийн байгууллагууд байсан юм гэхээр Монгол Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэг гэж байсан, МХЗЭ гэж байсан, МАХН гэж байсан. Ерөөсөө тэр үеийн МХЗЭ гэдэг нь залуучуудыг идэвхжүүлж байсан. Дандаа Урлаг, спорт, АСК гэдгээр. Авхаалж сэргэлэнчүүдийн клуб гэж тэмцээн явуулж, байгууллагуудын

дунд, бие биенээс өрсөлддөг, урлаг спорт, ажлаар ингэж өрсөлддөг. Тэр үед намайг манай хэвлэх үйлдвэрээс гадна манай аймгийн МХЗЭ-ийн Хороо гэж маш том байгууллага байсан. Тэр намайг товчооныхоо гишүүнээр элсүүлээд, намайг хөдөөгийн малчин залуучуудын ажил үйлсийг сурвалжлуулах, тэгээд илгээлт аваад мал дээр гарч байгаа малчин залуучуудын ажил амьдралтай танилцуулах, тэгээд тэр ажил үйлсээрээ шалгараад Дэлхийн залуучууд, оюутны их наадамд явуулах ч юм уу, том том арга хэмжээнд явж байгаа малчин залуучуудтай уулзуулж, тэд нарын тухай гоё сурвалжлагуудыг Хөдөлмөр сонинд нийтэлдэг байсан. Би тэр үед залуучуудын дуу хоолой бас болж байсан.

- **Interpreter:** после окончания университета, после приезда Ховд немножко изменилось. Она начало работать в редакции и это было большое учреждение. В этом учреждении тоже был комитет революционного молодёжи. Каждый работник был членом Монгольской Революционной партий. И ещё там здесь был аймочный союз революционных молодёжи и она стало членом этого союза. Это союз активизировала молодёжей и организовали такие конкурсы как КВН среди молодых работников. И они активно участвовали и одновременно они сам себя развивали. И её отправили худон чтобы встретиться с скотоводам и огородниками, а также чтобы взять интервью и потом прославляли их на газетах.
- ***Она была членом ревсомола, но ещё не членом партий. Но она потом стала членом партии?***
- Та хувьсгалт намд элсэж болж байсан уу?
- Тэр үед ажил үйлсээрээ сайн, тэргүүний хүмүүс хувьсгалт намд элсдэг байсан. Намайг элсүүлэх гээд бэлтгэж байсан. Тэгээд бэлтгээд хоёр жил болоод намын идэвхтэн гишүүн болоод явж байсан чинь ардчилал ил тод байдал, Горбачевын өөрчлөн байгуулалт эхлээд, тэгээд удаагүй байтал зах зээлийн нийгэм эхлээд. Тэгээд энэ хэвлэх үйлдвэр маань зах зээлийн шилжилтийн үе рүү ороод, ер нь сонин болоод үйл ажиллагаа нь таслагдаад. Дээрээс авдаг, тогтмол ирж байсан санхүүжилт, төсвийн бүх мөнгө нь зогсоод, тэгээд бие даах байдал руу шилжээд,

аж ахуйн нэгжийн тооцоонд шилжээд, бүх байгууллагууд тарж бутраад, нэг тийм хямралын байдалд орсон.

- **Interpreter:** она говорит в то время только передовые люди поступили партий. Но они приготовили её чтобы она стала членом партий и два приготовили её. Но в то время началась перестройка и остановилось финансирование типографии и редакций газеты.
- ***В каком году это было... приостановилась деятельность этой редакции?***
- Хэзээ санхүүжилт зогссон бэ, хэдэн онд?
- 90 оноос эхэлсэн. Тэгээд 90 онд хөдөлмөр сонинд би байж байгаад, редакци нь тусдаа гараад. Хөдөлмөр сонин хэвлэх үйлдвэр яг тэр хуучин газраа байгаад. Хөдөлмөр сонины редакци аймгийн энэ оффист нүүж ирсэн. Тэр чигээрээ тэрнээс хойш би энд ажлаад байж байна. Тэгээд нүүж ирээд сонин бол тогтмол гарч эхлээгүй. Бас их хямарсан. Төсвөөс өгдөг зардал хэмнэгдээд, алдаг оног хэвлэгдээд, 90 оноос хойш сонингууд зогсонги байдалд орсон, ерөөсөө бүх сонингууд. Хаяа хаяа нэг гардаг болсон. Тэгж байтал ардчилал гарч ирээд ихэнх аймгийн сонингууд зогссон. Тэгэхдээ бол ардчилалд шилжиж байхад сонин дээр ямар сэдэв зонхилж байсныг ярьж болох юм болов уу. Тэр үед бараа товар их хомсдоод, дэлгүүрээр бэлэн ирж байгаа талх гурилын нөөц их хомсдсон. Картын бараанд орсон. Тэр асуудлуудыг сурвалжлаад, бэлэн мөнгө авч байсан хүмүүсийн амьдрал нь яаж өөрчлөгдсөн юм бэ гэхээр. Жирийн малчид чинь яаж байсан юм. Тэр үед ажилгүй хүмүүс гэж байгаагүй ш дээ. Социализмын үед чинь бүгд л тодорхой хэмжээний ажилтай, орлоготой байсан.
- **Interpreter:** Это было в начале 90-ого года. При социализме не было безработица и все работали. Когда началась демократизация, появилась новая безработица и издательство газеты осталась на старом месте, а редакция пришла сюда и до сих пор работает здесь. Газета не так постоянно вышла, но так очень редк вышла газеты. Но они делали репортаж про карточных товарах, товары стали редко на полках магазинов. И они хотели делать репортаж как влияет это на жизнь людей и писали об этом на газете.

- ***А вот интересно, может быть, у неё здесь есть выпуски этой газеты, они могли бы нам показать?***
- Тэр үед картын барааны талаарх сурвалжлага гарсан сонин танайд хадгалагдаж үлдсэн байдаг уу, сонины дугаар?
- Тэр дугаар их ховорхон байгаа. Үнэхээр хайж олно гэвэл надаа зав цаг хугацаа хэрэгтэй.
- **Interpreter:** очень редко. Чтобы найти это должно долгое время.
- Номын санд бий юу ?
- Номын санд байж болох юм. Миний хувийн архив гэрт байгаа. Хайж олно гэвэл жаахан бэрхшээлтэй байна.
- **Interpreter:** У неё есть публичный архив дома. Чтобы найти нужно время, она также не помнить где это находится.
- ***Но в библиотеке будут эти газеты ?***
- **Interpreter:** Она говорит может быть там. Должно быть.
- ***А ещё что они печатали? Вот, например, 89-90-ые годы была демонстрация, что тогда они печатали об этом?***
- Тэгэхээр эгч ээ тэр 89-онд Ховдын оюутнууд жагссан ш дээ. Тэр талаар та сурвалжлага хийж байсан уу, юу бичиж байсан бэ?
- Тэр үед аймгийн сонингууд бараг зогсонги байсан. Үйлдвэр нь зогссон. Ганц манай хэвлэх үйлдвэр ч биш, барилгын бүх салбарууд зогссон, ахуй үйлчилгээний салбарууд гэж том байлаа. Бүх үйлдвэрийн газрууд бүгд зогссон.
- Тэгэхлээр тэр тухай мэдээлэл хэвлэлээр бараг байгаагүй юм байна, тийм ээ?
- Тийм. Тэгэхдээ тэр талаар бид нар дуу хоолойг сонин дээр гаргаж байсан.
- **Interpreter:** В то время остановилась деятельность. Поэтому не вышла газета об этих событиях.
- Тэр үеийн жагсаалын талаар бас 90 онд хэвлээр манай сонинд гарч байсан. Тэр оюутнууд одоо өөрсдийгөө ардчилалын партизанууд гэж нэрлэж байгаа ш дээ. Тэр үед би хүүхэд төрүүлээд, тэр үед жаахан чөлөө авсан байсан. Би санаж байна. Тэр

үед Зориг гуай манай аймагт ирж байсан. Тэгээд би түүнтэй уулзаад “Зориг Ховд аймагт” гэж мэдээ бичиж байсан.

- **Interpreter:** в 90 году она родила сына, она была в декретном отпуске. Но она сделала репортаж об этих событиях в 1990 году. И только Зориг основатель этого движения приехал сюда и она встретилась с ним. И она писала о нём в газете / заголовок “Зориг в Ховде” /.
- ***А вот как она его вспоминает, что у неё за встреча была, что о ней говорил ?***
- Тэгээд Зориг гуайтай уулзаад та юуны тухай ярьж байсан бэ, тухайн үед яах гэж уулзаж байв ?
- Тухайн үедээ Ховд аймагт ямар зорилгоор ирсэн юм бэ, тэгээд Ховд аймаг өөрийг чинь яаж хүлээж авна. Тухайн үед чинь ардчилал гарч ирсэн, ардчиллын үед хувьсгалт намд нь үздэггүй байсан ш дээ. Аягүй хурц үе байсан ш дээ. Тэгээд өөрийнх нь сэтгэгдлийг сонсоод, тийм тайван надад хариулж байсан. Одоо сайхан цаг ирнэ, нэг намын дарангуйлал гэж ярьж байсан, нэг намын тогтолцоог өөрчлөнө. Ардчилалыг бий болгоно. Тэр үед Ховд их сургуультай ирж танилцаад, тэр үед Ховд их сургууль ардчилалын дуу хоолой нь болж байсан. Ховдын их сургуулийн тэр оюутан залуучуудтай уулзаж байсан. Тэр талаар бичиж байсан.
- **Interpreter:** Она встретилась с ним чтобы узнать какие его цели, зачем он приехал сюда. Он ответил очень спокойно: “я приехал сюда чтобы распространять демократизацию и нам нужно изменить систему одной партий. И в скором времени у нас будет очень хорошее демократическое общество”. И он встретился с студентами Ховдийского университета. В то время члены Монгольской Народной Революционной Партий ненавидели Зорига.
- ***И здесь они как-то пытались на него влиять, эти члены МНРП, которые ненавидели его? Или они не встречались с ним?***
- Тухайн үед хувьсгалт намын гишүүд Зориг гуайтай уулзаж, түүнийг ятгаж болиулах ямар нэгэн оролдого хийж байсан уу ?
- Тийм оролдлого хийгээгүй.
- Зориг гуайтай уулзаагүй юу?

- Тийм. Зориг гуай харин өөрөө ирж намын удирдлагатай уулзаад явж байсан.
- Переводчик: Они не встретились с ним. Но он сам пришёл и встретился с руководителем Партий.
- ***А это было до марта 90-го года, или после того как правительство ушло в отставку ?***
- Зориг гуай 3 сарын өмнө ирсэн юм болов уу, эсвэл засгийн газар огцорсны дараа ирсэн юм уу?
- Өмнө нь ирсэн.
- **Interpreter:** Это было до...
- Өмнө нь дөнгөж ардчилал суурь тавигдах гээд л. Тэр үед чинь Баабар байсан, Сосорбарам, Бат-Үүл байсан. Тэд нар чинь жаахан залуучууд байсан. Чөлөөт залуучуудын эвлэл гараад л тэрний суурь тавигдаж эхэлсэн.
- **Interpreter:** только что в начале этого движения он пришёл.
- ***А она помнит, какой он на неё произвёл впечатление, вот он лично на неё? Я не знаю как там... как он был одет? Как он разговаривал? И что она тогда подумала об этом, о движение? Думал ли она тогда, что хороший исход будет у этого движения?***
- Тэгээд Зориг гуайн тухайд ямар хувцас хунартай, ямархуу хүн байв? Танд хувь хүнийх нь хувьд ямар сэтгэгдэл төрүүлж байв?
- Нүдний шилтэй, зангиатай, костюмтай, туранхай шар хүн байсан. Шар залуу байсан. Бид нар ч гэсэн тийм байсан. Насны хувьд бид нар чацуу. Даруухан хүн байсан.
- **Interpreter:** Они сверстники. В тот год он был в очках, в костюме, в галтуках. Он был очень худой, белое жёлтоватое лицо, тихий маленький, скромный был.
- Тогда она что думала об этой движени Зорига? Она думалаа, что оно получит какое-то распространение, или она думала, что как-то само посебе... потом как-то уйдёт?
- Та тухайн үедээ энэ ардчилсан хөдөлгөөнийг юу гэж хүлээж авч байсан бэ? Хөгжинө гэж бодож байсан уу эсвэл байж байгаад уначихна гэж бодож байсан уу?
- Баяртай хүлээж авч байсан.

- **Interpreter:** Она радостно восприняла это.
- Яагаад баяртай хүлээж авсан бэ?
- Өөдрөг, бүр ингээд хэтэрхий залуучуудын үзэл бодол чөлөөтэй. Тэр үед чинь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чаддаггүй байсан чинь. Тэр утгаар нь. Их хаагдмал, хэвлэл ч гэсэн их цензуртай байсан ш дээ. Галавлет гэж би дээр ярьж байсан ш дээ, тийм ээ. Ерөөсөө үг үсэг бүхнийг хянадаг. Тэгэхэд миний хувьд бол, сэтгүүлчдийн хувьд бол би аягүй их дэврүүн, хоббитой, сонирхолтой хүн байсан. Тэгтэл хүнд суртал зэргийг эвдэх залуу хүний сэтгэлгээг тухайн үед би дэмжиж хүлээн авч байсан.
- **Interpreter:** “Галавлет” был группа людей которые проверяли все ошибки и стиль написания в газете, а также что написано в газете, если напишут те информация которая не подходит в систему партий. Она в то время была против этого и из партий поставял цензуры и поэтому она очень радостно воспринял это движение. Всё было закрыто. Люди не могли свободно сказать свое мнение. Поэтому они думали что люди можно свободно высказать свои мнение, свои слова при демократизации.
- ***Расскажите, вот перестройка... она началась с 1986 года. Вот как они освещали перестройку вот в этот период... с 1986 по 1989. Были ли тогда какие-то статьи в газете о перестройке?***
- Тэгэхээр энд одоо 1986-1989 үед өөрчлөн байгуулалт явагдсан байна. Тэр үед энэ талаар та нар сонин дээр юм бичиж байв уу?
- Тэр үед өөрчлөн байгуулалтын тухай сэдвүүд бид нар МОНЦАМЭ –гийн гадаад харилцаа гэж хэвлэл сониноос бид нарт гадаад мэдээний сэдэв ирдэг байсан. Өөрчлөн байгуулалт ингэж явж байна. ЗХУ ингэж байна. Зөвлөлтийн коммунист намын байрь суурь ийм байна гэдэг ч юмуу. МОНЦАМЭ-гээр дамжиж манайд цахилгаанаар, факсаар мэдээ ирдэг байсан. Тэгээд сонингынхоо арын нүүрт олон улсын байдал гээд тавьдаг байсан. Ер нь өөрчлөн байгуулалтын талаар олон нийтлэлүүд гардаг байсан. Горбачевын тухай нийтлэлүүд, тэр үеийн комунистууд, удирдагч нарын тухай, манай намын удирдагч нарын тухай, өөрчлөн байгуулалтыг

ерөөсөө хүн болгон, фронт болгонд л нэвтрүүлэх талын тийм сурталчилгаануудыг бид нар хийж эхэлж байсан.

- **Interpreter:** В то время был такой, из МОНЦАМЭ прислали информация о международных позициях, и как идёт перестройка, про Горбачёва тоже писали. И в то время СССР и состояние этого государство тоже писали. Они старались распространять эти все информацию на всех фронтах страны.
- ***Вот материалы перестройки... тогда как она поступала? Попросили сверху дать такой-то, такой-то материал? Или кто-то мог снизу что-то предложить? А только перестройка идёт в Ховде. Или это сверху?***
- Тэгэхээр та хэд зөвхөн дээрээс ирсэн мэдээллийн дагуу өөрчлөн байгуулалтаар бичиж байсан уу эсвэл өөрсдөө бас эндээ санаачилж бичиж байсан уу?
- Өөрсдөө бас санаачилж, тэр үеийн Аймгийн АДХ-ын Гүйцэтгэх Захиргаа, Намын хороо гэж байсан, энэ одоо төрийн ордонд. Тэр үеийн ажлаа хариуцаж байсан хүмүүсээс бас өөрчлөн байгуулалтын тухай, МХЗЭ яаж өөрчлөн байгуулат хийж байсан, Монгол-Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэг юмыг яаж өөрчлөн байгуулж байна, өөрчлөн байгуулалт гэж юуг хэлээд байгаа юм гээд тухайн үеийн албан тушаалтнуудаас яриа авдаг байв.
- **Interpreter:** не только сверху, они взяли интервью по их инициативе. Это администрация называется оргкомитетом МНРП и ещё молодые журналисты тоже писали как перестройка влияет в местных аймаках. Такие статьи писали.
- ***Вот на какую тему были эти статьи перестроечные? О чём именно эти молодые журналисты писали ?***
- Тэр өөрчлөн байгуулалтын тухай нийтлэлүүд чухам юуг хөндөж бичиж байсан бэ?
- Тэр бас ерөөсөө удирдах дарга нар тийм ээ өөрсдийнхөө арга барилдаа яаж өөрчлөн байгуулалт хийх вэ, хүмүүстэй яаж ажиллах вэ. Том том бүтээн байгуулалтууд, үйлдвэрийн газрууд байна ш дээ тийм ээ. Тэр үйлдвэрүүдэд өөрчлөн байгуулалтын үйл явцыг яаж өрнүүлэх юм бэ, өөрчлөн байгуулалтын тэр дуу хоолойг тэдэнд хүргэж мэдээлж байсан. Мөн ЗХУ-д ийм өөрчлөн байгуулалт болж байна, ерөөсөө тэр үед чинь ЗХУ-г ах дүү орон гэж хэлж байсан. Ах нар гэж

ярьж байсан. Монгол-Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэг бас маш их хүчтэй, бас их гоё нэгдэлтэй байсан. Орос ах нарыг хүндэлдэг, тийм нийгэм байсан. Тийм учир тэр үеийн хүмүүс бол ЗХУ-д ийм өөрчлөн байгуулалт явагдаж байгаа юм бол бид ч гэсэн дагах ёстой гэсэн байр суурь, манайд бас ажилчин анги байсан, тэрийг ажилчин анги даган хүлээж байсан.

- **Interpreter:** в то же время была такая организация называется Дружба между Монголии и Россией. Это тоже была очень сильная и мощная организация. Монголы очень уважали русских в Монголии поэтому они говорили что если в России начинается перестройка, то в Монголии тоже нужно делать перестройку. И таким образом они принимали это понятие. И они писали в статье как руководители, наши вожди, директора заменяют свои методы с рабочими и как они распространяют эту перестройку. Каждая организация таким образом работала.
- ***В Советском союзе вот перестройку открывались так называемые ранние запрещённые темы, как например, какие эти явления в обществе были... например, там алкоголизм, там наркомания... что-то ещё... были репортажи в их газете в период перестройки?***
- Өөрчлөн байгуулалт эхэлсэнтэй холбоотойгоор Оросд хар тамхи, архи хэрэглэх нь задгайрсан юм байна. Манайд тийм юм болж байсан уу?
- Манайд тийм болж байгаагүй, яг тэр өөрчлөн байгуулалтын үед бол цэгцтэй хэвээрээ байсан. Яг нөгөө ардчилал гарч ирээд, 1996-1997 онд ардчилсан засгийн газар гарч ирээд л хөгжөөд ирэнгүүт хориотой, цензуртай байсан юмнууд задгайраад, тэрийг бас хүмүүс хэт хүний эрх гэдэг юмыг нэг талдаа тавиад, тэгээд туйльшрах байдлаар, тэрийгээ дагаад Хятадын зах зээлтэй харилцаа хобоо тогтоож байсан ш тээ, хятадаас янз бүрийн архи ихээр орж ирээд, архины наймаа хийдэг хүмүүс нэмэгдсэн байхгүй юу. Хятадын зах зээл бол тэрийг дэмжиж байсан, монгол руу архи оруулах сонирхол байсан. Хэт задгай байгаад, хил гааль хэтэрхий нээлттэй. Архины бизнес хөгжих, хүмүүс архинд донтох ийм замбараагүй байдал. Нэг талдаа ийм сөрөг үр дагавар, нөгөө талдаа одоо хувьчлал, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх байдал байгаа ч, эерэг сөрөг талууд бий болж эхэлсэн.

- **Interpreter:** в начале демократизация в Монголии такое явление не было. Только 1996 году наше Демократическое правительство начало относиться с Китаем, таможня открывался между Монголии и Китай и через границу люди привезли разнообразные спиртные напитки сюда. С одной стороны они слишком много употребляли спиртные напитки. Здесь есть положительные и не положительные стороны. Монголия стала открытая страна.
- ***Они печатали какие-то материалы о группах народного контроля? Народный контроль - такая была организация ... которая должна была контролировать деятельность предприятия, выявлять нарушения. Но если вы переводите народный контроль, она, наверно, сразу поймет, о чём идёт речь.***
- Тэр үед Ардын хяналт гэж байсан уу?
- Тийм, Ардын хянах шалгах хороо гэж байсан.
- Тэр одоо үйлдвэр, аж ахуйн газруудын үйл ажиллагаа шалгаж хянадаг байсан уу?
- Хянадаг байсан. Жишээлбэл, дэлгүүр, гуанз, цайны газрууд чинь тэр Хянан шалгах хороо гэж байх үед чинь хүмүүсийн эрүүл мэнд, эрүүл ахуйн талыг анхаардаг. Тэр үед нэг сайхан зүйл байсан ш дээ. Дандаа Оросын бараа таваар орж ирдэг, тэгээд хүнсний аюулгүй байдал гэсэн ойлголт байгаагүй. Бүгд угаасаа аюулгүй, эрүүл тийм сайхан байсан. Одоо ардчилал гарч ирээд янз янзын Хятадын зах зээлээс тиймээ, чанартай, чанаргүй бараа орж ирээд, одоо сөрөг тал гэж би ярьсан ш дээ тийм ээ. Тэрийгээ дагаад хүмүүс эрүүл мэнд маш муугаар нөлөөлж байгаа нь амьдрал дээр олон юман дээр ажиглагдаж байна. Гэхдээ үүнийг одоогийн төр засаг анхаарах хэрэгтэй. Тэр үед хүмүүс бүгд эрүүл байсан. Бүгд хөдөлмөрлөдөг байсан, хөдөлгөөний хомсдол гэж байхгүй байсан. Гүйдэг байсан, спортоор хичээлдэг байсан. Би ч гэсэн тийм л байсан. Гоё байсан.
- **Interpreter:** да такой народный контроль был. При социализме все товары импортировали в Монголию из России. Поэтому все товары были чистый и свежий, качественный. Поэтому у нас не было никаких проблемов, такие зависимые от продуктов. И ещё каждый человек имел свою работу, все занимались спортом поэтому все были здоровые. При демократизации из Китая импортировали не

качественные продукты и люди стали болеть от таких не качественных продуктов. В большинстве предприятий стали частными не государственным поэтому с одной стороны контроль стал обусловленным.

- 1989 онд 12-р сарын 7-нд Ховдод оюутнуудын жагсаал болоод тэр үед манай сонин тасалдаад эхэлсэн та хэлсэн. Тэгэхээр 1989 онд өөрөө МАХН засгийн эрх барьж байсан, улс төрийн товчоо үйл ажиллагааг явуулж байсан, Зөвлөлттэй эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн үйл ажиллагаа явж басан үе байхгүй юу. 1989 он, 1990 оны 3 сар хүртэл монгол бол хуучин социалист тогтолцоо байсан гэж болохоор. Тэгэхээр 1989 онд сонин санхүүжилтгүй юмуу юунаас болоод зогссон бол? /Энхбаатар/
- Тэр чинь нэг яаманд харъяалагдаж байсан байхгүй юу. Соёлын яам гээд л... тэр хүн чинь Зардынхан бил үү. Тэгээд 1988, 1989 онд сонин гарч байсан ш дээ. Харин 1990, 1991 онд сонин тасалдаж эхэлсэн.
- Тэр өөрчлөн байгуулалтын тухай, тэр аймгийн намын хорооны дарга нарын ажлын арга барилыг өөрчлөх тухай нийтлэл хэвлэх явцад ямар нэгэн байдлаар Утга зохиолын хэлтэс тэндээс ямар нэгэн байдлаар хянан шалгах, боох асуудал ямар байсан юм бол. Өөрчлөн байгуулалтын тухай томоохон нийтлэлүүд хэвлэгдсэний дараа Ховдын хөдөлмөрчид хэрхэн яаж хүлээн авч, хэрхэн яаж санал бодлоо илэрхийлдэг байсан юм бол? /Энхбаатар/
- Тэр бол өөрчлөн байгуулалт, одоо тэр сонин дээр гарч байгаа нийтлэлүүдийг чинь ерөөсөө нөгөө нэг байгууллага дээр сонин уншлага, лекц уншдаг байсан. Байгууллага, байгууллага өглөө болгон уншдаг ч юмуу тухайн үеийн хүмүүс тэр үеийн мэдээллийг авдаг байсан. Жишээлбэл, өглөө 7.30-д мэдээлэл авна, орой ажлаа тараад мэдээлэл авна. Нэг болбол бүгдээрээ эвлэлийн гишүүдийг цуглуулж байгаа лекц хийнэ, эсвэл байгууллагын ажилчдыг цуглуулж байгаад лекцээр мэдээлэл өгнө. Иймэрхүү байдлаар хүмүүс мэдээллийг авч байсан. Тэр мэдээллийг хүлээж авснаар хурц огцом өөрчлөлтөнд орж байгаагүй. Үйл явдал аажим аажмаар явдгаараа яваад л, зах зээл рүү шилждэгээрээ шилжээд л, яг нийгмийн тогтолцоо бол хэвийн тайван уур амьсгалтай бий болж эхэлж байсан. Ардчилалын

1989-1990 онд төр засгийн дээрээсээ өөрчлөлт гарч эхэлсэн ш дээ. Яам тамгууд өөрчлөгдөх ч юмуу, зах зээлийн дагуу байгууллагууд төвлөрсөн төсөв авахгүй, аж ахуйн тооцонд орж ажиллаж эхэлнэ ээ гээд л, хэн илүү хийсэн нь авна, хийгээгүй нь авахгүй гээд л тиймэрхүү зарчмаар хэрэгжээд л эхэлсэн гэж бодож байна. Хувьчлал юм гэж гараад... тэр хувьчлал ерөөсөө буруу явагдсан гэж үздэг. Тэр хувьчлал гэж яригдаад л 90 оноос эхлээд тийм ч аж ахуйн нэгжийг хувьчлана, тийм ч дуудлага худалдаа гээд л том том компаниудын барилгуудыг дуудлага худалдаанд оруулаад л, тэр том объектуудыг..тэр хувьчлал чинь нэг хүний харъяанд ороод л, дээрээсээ социализмын үеэс ирдэг байсан төвлөрсөн санхүүжилт зогсонгуут, тэр хүмүүс биеэ дааж ажиллах чадвар байхгүй улмаас эхнээсээ хаалгаа барьж эхэлж байгаа байхгүй юу. Манай аймгийн барилгын салбар бол маш том салбар байсан. ЗХУ-ын түршлагаар ажилладаг, дандаа зөвлөлтийн лозунг бичсэн. Ажлын байрууд байсан. Тэр социалист уралдаанд тийм үүрэг даалгавар авлаа, ЗХУ-ын КН болон МАХН-ын тийм одоо даалгаврыг биелүүлнээ гэдэг ч юм уу тийм уриатай байсан. Тэр бүр чинь хаагдаад ирж байхгүй юу, тэгээд л хаалгаа бариад л. Хувьчлал гэдэг юм чинь явагдаад л. Тэр үед чинь хувчлал гэдэг юм чинь нэг талдаа хэцүү явагдсан ш дээ. Бодлого байхгүй, ямарч бэлтгэлгүй, тэр үед хүмүүсд сэтгэл зүйн хувьд бэлтгэл байгаагүй. Олон хүн ажилгүй болсон, эндээс эхлээд ажилгүйдэл бий болж эхэлсэн. Тэгээд хямрал бий болсон. Тэгээд цаашдаа одоо яахав гээд үйлдвэр нь зогсчихсон, ажилгүй болчихсон бид нар одоо яахав, надад ч гэсэн дайрч байсан. Сонин одоо зогсчихсон тэгвэл одоо би яахав. Тэр хүмүүс өөрсдөө одоо юу хийж чаддаг юмаа хийж эхэлж байсан. Талх гурилан бүтээгдэхүүн хийдэг бол талх гурил бүтээгдэхүүн хийгээд л, хотоос жижиг бараа авчраад нэг нугалаад л. Оросоос ч юмуу бараа авчраад 50 төгрөг нэмээд л, мөн Хятадаас бараа авчраад л зараад л. Тохиролцооны дэлгүүр гэж ажиллуулаад л, зах гэж аймаг дээр бий болоод л. Анхны зах манай энэ Жаргалант суманд байгуулж байсан ш дээ, зам анги гэж байсан тэнд. Зам барилгын олон том том бүтээн байгуулалтуудын юмнууд тэр хувьчлалын нэрээр ингээд устаад, хаалгаа барьсан ш дээ. Ардчилал эхэлсэн нь сайн үр дагвар авчирсан ч гэсэн бас сөрөг олон үр дагварууд бий болсон ш дээ. Тэгээд

тэрийгээ нөхөж хөгжих гэж хүмүүс хүчин мөхөсдөж байна ш дээ. Тэгээд л зах зээлийн нийгэм чинь хоёр талтай юм шиг байгаа юм. Сайн судлаж, дээрээсээ төр засаг нь ард түмнээ сайн замбараатай удирдахгүй л болбол одоо тэр ажилгүй болсон хүмүүсээ яахав ээ тийм ээ. Яахав нэг үеэ бодвол зах зээл гэдэг нь хөгжөөд зах дээр наймаа эрхлэгчид, янз бүрийн бараа зарж байгаа хүмүүсийн амьдрал эрс өөрчлөгдөөд сайжраад эхэлсэн. Тэгээд барааны дэлгүүр, янз бүрийн хүсний дэлгүүрүүд бий болж эхэлсэн, нэг үеэ бодвол, аажмаар аажмаар хүмүүс хөл дээрээ боссож эхэлж байна. Тэр үед зээл бий болж эхэлсэн ардчилал эхлэхэд. Орон сууцтай хүмүүс орон сууцаа хувьчилж аваад цааш нь өндөр үнээр өгөөд тэрүүгээр цаашаа амьдралаа аваад явж байгаа хэсэг бүлэг хүмүүс бий. Тэр бүр орон сууцтай байгаагүй, сэтгэл зүйн хувьд бэлтгэлтэй байгаагүй, ерөөсөө хувийн юм хөгжих суурь юмгүй байхад хувьчлалыг явуулсан.

- **Interpreter:** в начале этого движения по прежнему общество напряженно работало. Государство дали государственные предприятия к частных руках. Частные люди которые привитизировали эти предприятия не могли работать самостоятельно. По её мнению, привитизация прошло не правильно. Из-за этого почти все предприятия остановились поэтому появились безработные люди. Люди которые стали безработными стали делать разные вещи. Некоторые люди делали булочные продукты, некоторые люди продавали свой дом и занимались бизнесом, некоторые привезли товары из России или Китая и прибавляли цену и продавали здесь. По сравнению того времени, бизнесмены которые начали заниматься бизнесом сегодня стали хорошо жить и стал богатыми.
- Тэр үед хувийн сонин үүссэн үү? **/Энхбаатар/**
- Хувийн сонин би гаргасан ш дээ. Залуучууд бас Цацал гэдэг сонин гаргаж байсан.
- Тэр үед юуны тухай бичиж байсан бэ? **/Энхбаатар/**
- Тэр үед тухайн үеийн төр захиргааны байгууллагуудын тухай, зах зээлийн хүмүүсийн аж амьдралын талаар бичиж байсан. Дараа нь 2004 онд миний ажиллаж байгаа энэ сонин, хувийн сонин байхгүй юу. Ерөөсөө олон аймагт аймгийн сонин зогссон ш дээ. Ерөөсөө үзэл сурталын зэвсгүүд зогссон ш дээ. 13 жил бараг

энэ бүх аймагт давтагдсан байхгүй юу. 10-аад жил зах зээлд ороод бүх аймаг сонин байхгүй байсан. Тэгээд би 2002 онд энэ сонингоод эхлээд, хуучин суурь нь надад мэргэжил байсан, боломж байсан, үр чадвар байсан, сонирхол байсан учраас би үүнийг дахиад аваад эрхлээд хүнд үед гаргаж байсан. Одоо ч хүнд л байна. Ер нь сонины асуудал бие дааж явахад хүндрэлтэй байдаг.

- **Interpreter:** это тоже частная газета. 2002 году она решила начать выпускать частную газету. Но это было трудное время. Сейчас тоже трудно.
- А вот когда в начале 90-х, 91, 92 тогда появлялись частные газеты?
- **Interpreter:** Она говорит что почти 10 лет на всех аймаках остановились печатать.
- ***Тоесть никакой не было например жёлтые прессы 90-х годов?***
- Тэгэхээр аймгуудад 90-оны үе тэр шар сонин гарч байгаагүй юу?
- Аймгуудад шар сонин гарч байгаагүй. Чөлөөт үзэл бодлыг тодорхой хэмжээгээр илэрхийлж байсан. Төвөөс янз бүрийн шар сонин орон нутагт ирээд л тэрнийг уншиж байсан.
- Тэр Цацал сонин хэдэн онд гарч байсан уу?
- Цацал 90-нд гарч байсан. 1, 2 дугаар гараад хаачихсан.
- **Interpreter:** В начале 90-х годов “Цацал” газета вышла. Но только 1, 2 номера выпускались. Но потом остановилась выпускать. Аймачные жёлтые прессы не были.
- ***А из Улаанбаатара что–нибудь поступало, из частных новых газетот или жёлтая прессы?***
- УБ-т тэр үед хувийн хэвлэл гарч байсан уу?
- Гарч байсан. Зөндөө янз янзын сонингууд гарч байсан. Ардчилал сонины дараагаар ёстой ар араасаа чөлөөт хэвлэлүүд гарч байсан, жинхэнэ шар хэвлэлүүд бий болсон доо.
- Ардчилал бол яг шар сонин биш ш дээ. Шар сонин гэх юм бол одоо 17-18 жил болж байгаа “Сэрүүлэг”, за тэр нөгөө нэг хаалттай сонин “Халуун хөнжил” эд нар жинхэнэ шар хэвлэл чиглэл рүүгээ хөгжиж эхэлсэн. Ардчилал бол өөрөө Ардчилсан холбоо, Ардчилсан намын сонин гэдэг утгаараа улс төрийн чиг агуулгатай, ухуулгын шинж

чанартай сонин байсан ш дээ. Тэрнийг дагаад янз янзын одоо монголд одоо байгаа сонингуудын чинь ихэнх нь одоо тэгээд л , мөн өдөр тутмын “Өнөөдөр” гээд сонингууд гарч ирсэн ш дээ. /Энхбаатар/.

- **Interpreter:** Он говорит, что Газета “Ардчилал” не была жёлтой прессой. Это политическая газета. А “Сэрүүлэг”, “Халуун хөнжил” газеты являются жёлтой прессо.
- “Сэрүүлэг”, “Дээдсийн хүрээлэн”, “Хүмүүсийн амьдрал” сонингууд гарч ирээд, менежмент гэдэг утгаараа захиалагчдаа хонжвор азтан тодруулна гэж хэрэглээд л, анхны хувийн телевиз гээд. Анх улсын нэртэй Өлзий студи гээд Улаанбаатар телевиз байгуулагдаад, дараа нь Алтайгийн 25-р телевиз гарч ирсэн. Тэгээд л цаашлаад бусад телевизүүд гарсан. Сонингуудын хувьд Улаанбаатарт илүү түлхүү гарсан байх. /Энхбаатар/
- ***Такой вот вопрос к ней. Какой она жизненный период вспоминает как самый хороший и какую специальность её дети получают?***
- Эгчээ таны амьдралд хамгийн дурсгалтай үе хэдий үед тохиож байсан бэ? Таны хүүхдүүд одоо ямар мэргэжилтэй вэ?
- Хамгийн дурсгалтай юм болбол 1985 онд МУИС төгсөж ирээд өөрийнхөө мэргэжлээр сэтгүүлчийнхээ мэргэжлээр ажлаад л тэгээд тэр үед сэтгүүл зүйн бүтээлүүд ид туурвиад, сурвалжлага ярилцлага, бүх жанруудаар өөрийнхөө хүчийг сориод, хөдөө орон нутгаар яваад малчидтай уулзаад л байгууллагуудаар яваад л дарга нартай уулзаад л. Яг ажлын талбар дээр бүтээн байгуулалтын барилгын салбар дээр явж байсан тэр үеийн сурвалжлагууд, тэр үед яг сайхан дээл оёж байсан хүн яг социализмын үеийн бүтээн байгуулалт, үйлдвэрлэл бүтээн байгуулалт явагдаж байсан тэр үеийн сурвалжлагууд надад бас сайхан сэтгэлдэлд үлдээж, хоногшсон байдаг. Би 3 хүүхэдтэй. Нэг нь миний мэргэжлийг эзэмшсэн, нөгөө хоёр нь нягтлангийн чиглэлээр сурч байгаа өөрийнхөө мэргэжлийг эзэмшүүлэхгүй гэж. Тэгээд манай гэр бүлийн хүн дуу бүжгийн багш мэргэжилтэй. Монголын нийгэм ямар замаар явж, ямар бэрхшээлийг давж, ямар бэрхшээлтэй тулгарч байсан тэр бүх л нийгмийн тогтолцоог миний амьдрал дээр гарч байсан. Би

бол ажилгүй болж үзсэн, амьдрал хэцүү байж үзсэн, талхны мөнгө олох гэж зовж үзсэн, би өөрөө сонин хэвлэл зогссон үед би өөрөө хүүхдээ хараад нарийн боов хийх ч юмуу түүнийгээ зарах ч юмуу тиймэрхүү байдлаар талх боов зарах гэж оролдож байсан. Тэгээд амьдрал хэцүү байсан. Намайг сургууль төгсөөд ирэхэд ажилгүй байж байх үед 1995, 1996 оны үед Аймгийн Хянан шалгах хороо дахин байгуулагдаад, тэнд намайг нарийн бичгийн даргаар авсан. Тэнд би ажиллаж байхдаа үзэл суртлын зэвсэг тэр хянан шалгах хорооны дуу хоолойг хүмүүст хүргэж байсан. Радио нэвтрүүлэг гэж явж байсан. Тэгээд би радио үзельд очоод мэдээ бэлтгээд нэвтрүүлэг явуулдаг байсан. Хичнээн сонин байхгүй байсан ч. 1997 онд Монгол оронд Хэвлэлийн хүрээлэн гэж байгуулагдаад монголын 5 бүсэд салбараа нээсэн. Тэр нь баруун бүсийн төв байсан. “Ардчилал сэтгүүл зүй” гэсэн төсөл баруун бүс бүх аймгийн салбарт хэрэгжүүлж эхэлсэн. Тэрний төслийг хэрэгжүүлэхээр би баруун бүсийн зохицуулагчаар ажиллаж байхдаа би бас яг одоо орон нутагт хэвлэл мэдээлэлийн байдал ямар байна, орон нутгийн сэтгүүчдийн суурь сэтгүүл зүйн мэдлэгийг яаж дээшлүүлэх, сэтгүүлчдийг мэдлэгийг дээшлүүлснээр нийгэмд болж байгаа үйл явдлыг илүү илт тод болгоно тийм ээ, тэгээд олон түмэнд илүү нээлттэй хүргэхэд яаж ажиллах вэ, мэдээлэлийн зах зээлийг яаж хөгжүүлэх вэ гэдэг дээр Увс, Баян-Өлгий, Ховд аймгууд дээр сургалт явуулж байсан, сэтгүүлчдийг чадавхжуулах, янз янзын сургалтууд явуулж байсан. Тэр төслийг дууссаны дараа 2002 онд энэ Ховдын мэдээ гэдэг сонинг бие даасан чөлөөт хэвлэл болгож 10 хоног тутам гаргаж байсан. Тэгээд энэ сонинг гаргахад тийм сайхан байгаагүй, мэдээж надад хэцүү байсан. Мөнгөний асуудал байсан. Сонингоо хотод хэвлэнэ, надад компьютер ч байгаагүй. Зөвхөн тэрийг хэвлэх юмсан, хүн ардын аж амьдралын талаар мэдээлэх олон нийтэд хүргэх юмсан хүсэл эрмэлзэл байсан болохоор надад мөнгө байгаагүй. Тийм учраас би сэтгэлээрээ сонин гаргаад нойртой, нойргүй хоноод гаргахад манай ховдын олон ястан ард түмэн аягүй сайхан тэр мэдээлэлийг яг хүлээж байсан. Чадах чадхаараа хүмүүс дэмжсэн, захиалах нь захиалаад. Сумуудаар явж сонингоо сурталчлаад, айлуудаар явж байхад Ховдын мэдээ аягүй гоё хүлээж авч байсан. Ховдын хөдөлмөр сонин үргэлжлэл гэж настай хүмүүс нь хүлээж авч байхад

дундын үеийн хэсэг нь шинэ сонин мэдээлэл гарч ирж байна, үнэхээр хэрэгцээтэй байна өөрийнхөө тухай нийтлэе гэдэг ч юмуу, манай суманд ийм үйл явдал болж байна шүү гээд л. Сум болгоны үйл явдлыг хүргээд л, хүмүүстээ тараагаад л. Манай сонин байгуулагдаад одоо 10 жил болж байна. Тэгэхдээ ч гэсэн ер нь сонин авч явахад хэцүү. Бид нар хоёр удаа шилдэг нийтлэлийн бодлого, улсдаа шилдэг сонингоор 3 удаа 2005, 2008, 2010 болсон. Тэгээд тэр үедээ би залуу сэтгүүлчдийг дадлагажуулж сургаж байгаа. Одоо би бас ерөөсөө байгаль орчны сэдвийг илүү давамгайлж байна даа. Байгаль сэтгүүлчдийн клуб гэж байгуулаад тэнд янз янзын хүмүүс үзэл бодлоор нэгдэж байна. Янз бүрийн гоё мод жимс ногоо тарьдаг хүмүүсийг туршлагыг бусдад нь түгээдэг ч юмуу, хүмүүсийн байгальд хандах хандлагад нөлөөлөх зорилгоор ийм байгалийн сэдэв рүү илүү түлхүү орж байна даа. Сонин маань одоо тогтмол гарч байна. Тэгэхдээ л бас их хэцүү л байдаг, хүмүүсээ цалинжуулж чадахгүй. Сонингынхоо эхийг энд бэлтгээд хотод хэвлэдэг. Ховдод ирээд тараагддаг. Маш их өндөр зардалтай хэвлэгддэг. Сонин бол хэцүү л дээ сонингоос өөр юм хийж чадахгүй болохоор, энэтэй зууралдаад л. Энэ сонинд бол сайхан сэтгэлтэй хүмүүс л ирдэг. Мөнгө олох гэж бодоогүй, зөв хандлагатай, зөв дадалтай хүмүүс л ирдэг. Тэрнээс биш одоо яг мөнгө олъё, баяжъя гэсэн хүмүүс ирэхгүй. Яагаад хүмүүсд зөв мэдээлэл хүргэж, хүмүүсийн дуу хоолой болж нийгмийн хөгжилд түлхэц өгөх, сонин бол эерэг нөлөөтэй учраас ухуулга сурталчилгааны хүчтэй зэвсэг ш дээ. Энэ сонингоос гадна янз янзын вэбхуудаснууд, янз бүрийн өдрийн сонигуудтай бас холбоотой ажиллаж байна. Ховд аймгийн тухайн, ховдын хязгаарын тухай мэдээллийг маш олон газарт хүргэж байна. Тийм л байна. Би та нарт их сайн бэлтгэлтэй байж чадсангүй. Би цаг байсан бол тухтай ярилцах байлаа. Тэгээд уучлаарай өнөөдөр бас хот руу явах ажилтай, тайлан гээд л. Та нарын хүсэж байсан асуултанд би хариулж чадаагүй бол намгайг уучлаарай.

- **Interpreter:** У неё мало времени. Если что, она извеняется в том, что не могла... во многих вопросов, так как у неё времени нет.
- **Их баярлалаа.**

- **Interpreter:** 1985 году был очень вспоминающий год. Она только что приехала и активно работала. Разные периоды она жила трудно, во время перестройки она пекла хлеб сама и продала их. У неё три ребёнка. Старший ребёнок стал журналистом. А две дочери учатся на бухгалтера. А его муж преподаватель музыки и пений. Потом она начала работать в проекте, где обучали новых журналистов, а также повысить их квалификаций. Это проходило в Увсе, в Баян-Улгий, в Ховде. Таким образом она работала. 2002 году она создала эту частную газету и старшее поколение принимало эту газету как продолжение газеты “Труд”, а среднее поколение думали что хорошая газета с множественными информациями о Ховде и о сомоне. Очень многие семьи поддерживали её работу и очень хорошо относился с ней. Но сейчас до сих ей трудно вести эту работу этой редакций. Потому что это базирование находится здесь и собирает материалы и приготовить их на компьютере, и потом печатает в Улаанбаатаре. Поэтому большие расходы требуется ей.
- **А газета печатается в Улаанбаатаре, не здесь?**
- **Interpreter:** Да. Но в начале 2002 году ей не достаток деньги. Даже компьютеров ей не были. Сейчас новые люди работают не за деньгами, только для распространение информации.
- За таныг цаг зав гаргаж ярилцсанд маш их баярлалаа гэнээ.
- Би одоо үнэхээр бас завгүй байсан шүү, уучлаарай. Завтай байсан бол юмаа судлаад ирсэн бол зөндөө л юм ярих байлаа. Би та нарт сонингоо өгье тиймээ. Манай сонинуудаас авбал бас зүгээр тиймээ. Би нөгөө энэ Байгаль сэтгүүлч гэсэн клубынхаа ажлаар Бээжинд Дундад Азийн орнуудын уулзалтанд очиж оролцоно. Тэгээд тэр Азийн орнууд яаж байгалийн сэдвийг олон нийтдээ хүргэдэг юм бэ, цөлжилттэй яаж тэмцдэг юм бэ гээд тэр талын би судалгаа сургалтанд суухгаад ингээд явах гэж байна.
- **Interpreter:** Она тоже работает в клубе “Природа-журналист” и по этой линии она собирается участвовать в митинге в Пекине. Если ей была бы много времени она

говорить, что она могла бы нам рассказать очень хорошие материалы, статистики, которые у неё дом. К сожалению, ей нету времени сейчас.

- Тэр үеийн бүтээн байгуулалтын хүмүүстэй уулзана гэвэл таньдаг хүмүүсийг зааж өгч болж байна. Энэ Ховдын Багшийн их сургуулийн түүхийн багш Ганболд гэж хүн байна. Манай тэр аймгийн хуучин дарга нараас одоо ихэнх нь байхгүй байна. Манай тэр үеийн эвлэлийн хороонд ажиллаж байсан хүмүүсээс байгаа. Зарим нь бас амарчав уу яав. Сураглаад асуувал та нарт бас хүмүүс зааж өгөх байхалдаа.
- **Interpreter:** некоторые люди были здесь, которые работали здесь в начале 90-х годах. Но сейчас они может быть в отпуске. Здесь нет.
- ***А скажите ей, что вот сейчас мы идём в библиотеку. Мы будем искать там эти газеты и может быть, если там мы ничего не найдём, могли бы мы ей тогда позвонить, может быть, когда у неё будет время, она, может быть, что-нибудь в своём архиве бы отыскала.***
- Бид энэ номын санд очих юм бол эгчээ тухайн үед гарч байсан үйл явдлын талаар, яг тэр өөрчлөн байгуулалтын талаар мэдээ сурвалжлага бүхий сонинг номын сангаас олж болох болов уу?
- Болно. Номын сангийн эрхлэгч нь хэлж өгөх байх. Тэр үед номын сан гэж байдаг байсан.
- Хэрвээ номын сангаас тийм мэдээллийг олж чадахгүй бол та хэзээ явах вэ?
- Би өнөөдөр 1 цагаас явна. Би олж амжихгүй. Завтай бол туслах байсан.
- **Interpreter:** может быть... мы в библиотеке не можем найти. Она сегодня летит в 13.00 часов.
- ***Их баярлалаа. Их сонирхолтой байсан. Хорошей поездки Вам.***